

БАТЛАВ.
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.ДАВААЖАРГАЛ

АТАА12931 6594204 9024070548

ХИЛ ОРЧМЫН БОЛОН ХИЛ ДАМНАСАН АЯЛЛЫГ ХӨГЖҮҮЛЖ, ХӨВСГӨЛ НУУРТ
ТУЛГУУРЛАСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮСИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

1.	Үндэслэл:	<p>Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ”, 8.2.2-д Хөвсгөл нуур, Хангайн нурууны экосистем, томоохон голуудын сав дагуух адал явдалт болон Орхоны хөндийн дурсгалт газрыг түшиглэсэн соёлын аялал жуулчлалын цогцолбор байгуулна.</p> <p>Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 3.3.1.Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 1.3.3.1.Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.</p> <p>Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйл, 16.1. “Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.”;</p>
2.	Зорилго:	Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлж Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт тулгуурлан улсын аялал жуулчлалын тусгай бүс тогтоон хөгжүүлэх.
3.	Байршил:	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар
4.	Хамрах хүрээ:	Хөвсгөл аймаг, Алаг-эрдэнэ сумын Хатгал тосгон, Ханх, Чандмань-Өндөр, Цагаан-үүр, Ренчинлхүмбэ, хил орчмын бүс нутгийг хамарсан газар нутгийг мөн тус аймгийн аялал жуулчлалын бүсийг хамруулах.
5.	Ашиглах материал:	Монгол Улсын хуулиуд: - Монгол Улсын Үндсэн хууль - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;

		<ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль; - Соёлын өвийг хамгаалах тухай хууль; - Аялал жуулчлалын тухай хууль; - Ойн тухай хууль - Усны тухай хууль; - Хамгаалалтын бүс тогтоох тухай; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Байгалийн ургамлын тухай хууль /нэн ховор, ховор ургамлын жагсаалт/; - Амьтны тухай хууль - Гамшгаас хамгаалах тухай хууль; - Галын аюулгүй байдлын тухай хууль; - Газрын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Байгаль хамгаалах олон улсын холбоо /IUCN/-аас гаргасан Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт "Тогтвортой хөгжлийн удирдамж" гарын авлага, 2020 он - Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөгдөх нэгдсэн өнгө төрх, загварыг батлах тухай БОАЖС-ын 2018 оны А/498 дугаар тушаал - Бусад холбогдох дүрэм журам, стандарт, баримт бичиг, Норм, нормативууд
6.	Баримт бичгийн иж бүрдэл:	<ul style="list-style-type: none"> - Судалгаа, үнэлгээ тооцооллын аргачлал арга зүй; /Материалд дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнгийн нэгтгэл, иргэд оршин суугч, төлөвлөлтийн бүсэд хийгдсэн судалгаа зэрэг бусад шаардлагатай материал/ - Инженер-геологийн дүгнэлт - Төлөвлөлтийн талаарх танилцуулга - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын тооцоо <p>Зураглалын бүрдэл:</p> <p><u>Судалгаа, үнэлгээ тооцооллын зураглал</u></p> <ul style="list-style-type: none"> - Зургийн жагсаалт, тайлбар бичиг - Байршлын схем М1:25000; - Орчны тойм М1:10000-25000; - Байр зүйн дэвсгэр зураг М1:2000; - Авто зам тээврийн сүлжээ М1:5000; - Барилгажилт М1:5000; - Газар ашиглалтын судалгаа М1:5000; - Газар ашиглалтын бүсчлэл М1:5000; - Түүх соёл, аялал жуулчлал М1:5000; - Гамшгийн менежмент М1:5000; - Ногоон байгууламж, спорт, амралтын талбай М1:5000; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ М1:5000; - Дулаан хангамж М1:5000; - Ус хангамж, ариутгах татуурга М1:5000; - Цахилгаан хангамж М1:5000; - Нийгэм-Эдийн засгийн үнэлгээ М1:5000 - Дэд бүтцийн үнэлгээ М1:5000

		<ul style="list-style-type: none"> - Архитектур, түүх, соёл, археологийн дурсгал, ландшафтын үнэлгээ M1:5000 <p><u>Төлөвлөлтийн зураглал</u></p> <ul style="list-style-type: none"> - Зургийн жагсаалт, тайлбар бичиг; - Газрын нэгдмэл сангийн ангилал M1:10000-15000; - Гудамж, замын сүлжээ M1:2000; /батлагдах хуудас/ - Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл M1:2000; /батлагдах хуудас/ - Ерөнхий төлөвлөгөө M1:2000; /батлагдах хуудас/ - Архитектур орон зайн төлөвлөлт, барилгажилт M1:2000; - Газар зохион байгуулалтын төлөвлөлт M1:5000; - Ногоон байгууламж, спорт, амралт, аялал зугаалгын бүс M1:5000; - Соёл, ахуй үйлчилгээний ангилал, үйлчлэх хүрээ M1:5000; - Аялал жуулчлалын менежмент нэгдсэн төлөвлөлт M1:5000 - Тусгай хамгаалалттай бүс хориглох, хязгаарлах дэглэмтэй бүсүүдийн төлөвлөлт M1:5000; - Дугуйн зам, хөсөг тэрэг, явган замын төлөвлөлт M1:5000; - Нийтийн тээврийн нэгдсэн зогсоол, авто машины зогсоол, төлөвлөлт M1:5000; - Гадна зам тээврийн сүлжээ M1:10000-25000; - Гамшгийн менежмент нэгдсэн төлөвлөлт M1:5000; - Хог хаягдлын нэгдсэн төлөвлөлт M1:5000; - Төлөвлөлтийн үе шатны зураглал M1:5000; - Төлөвлөлтийн хүрээнд шинээр дахин төлөвлөх, сэргээн засварлах, хамгаалалтад авах бүс M1:5000; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам M1:2000; - Үерийн хамгаалалт, далангийн зураг M1:5000; - Инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас M1:5000; - Инженерийн дэд бүтцийн нэгдсэн зураг M1:2000; /батлагдах хуудас/ - Ус хангамж, ариутгах татуурга M1:2000; - Цахилгаан хангамж M1:2000; - Холбоожуулалт M1:2000; - Ерөнхий харагдах байдал /3D зураг/ <p>Тоон материалын бүрдэл:</p> <ul style="list-style-type: none"> - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний товч тайлбар 2-3 хуудас байх/*.doc, *.pdf/ - Товч танилцуулга 25-аас ихгүй слайд байх/*.ppt/ - Төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн 2 минутаас багагүй байх./*.mp4; 720HD/ - Ажлын үе шатны зураглалын бүрдэл /*.dwg, *.pdf, *.jpg/ - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлыг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд хүлээж авахад тавигдах үндсэн шаардлага болон бусад холбогдох материал тусгах.
7.	Хийгдэх ажил	<p>Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт Аялал жуулчлалын тусгай бүсийн хөгжлийн нийтлэг концепцийг тодорхойлж, цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> - Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн алсын харааг тодорхойлох - Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт, Хөвсгөл нуурын орчимд дээд зэрэглэлийн аялал жуулчлалын цогцолбор байгуулах

- Тухайн бүс нутгийн хэмжээнд уг төсөл ямар нөлөөлөл үзүүлэх, түүх соёлын ач холбогдлыг тодорхойлох;
- Түүх соёлын биет өв болон соёлын биет бус өвийг судлан хууль эрх зүйн хүрээнд хамгаалалтад авах арга аргачлалыг тодорхойлох;
- Гадаад, дотоодын нийт зорчигчдын тоо, жилд үйлчлэх жуулчдын эрэлт, нийлүүлэлтийн хүчин чадлыг судалж, төлөвлөлтийн шийдэл гаргах
- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах төлөвлөлтийн хязгаар тогтоох
- Газар ашиглалтын болон эдийн засгийн судалгаа, үнэлгээг гаргаж төлөвлөлтийн шийдэл гаргах
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын судалгаа, дүгнэлт гаргах
- Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний суурь судалгаа гаргах

Аялал жуулчлалын орон зайг тодорхойлох

- Монгол улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгийн бодлого, төлөвлөлтийг үндэслэн урт, дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдааг хангах
- Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлж аймаг, орон нутгийн хүн амын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэх
- Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэх;
- Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын орон зайн төлөвлөлтөд отоглох цэгүүд, эко аяллын бүс, хамгаалах шаардлагатай бүс, бүсчлэлийг тодорхойлох
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийн тогтолцоо, сайн туршлагыг тодорхойлсон зөвлөмж боловсруулах;
- Хөвсгөл нуур орчимд аялал жуулчлалын кластер хөгжил, бүс нутгийн таталцлыг тодорхойлох
- Аялал жуулчлалын үндсэн цогцолборын нөхцөл, нөөцийн шинжилгээ, хүчин зүйлийн үнэлгээ, бүтээгдэхүүн – үйлчилгээ, бизнес хөгжлийн загвар, орон нутгийн ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээ, хүний нөөц болон холбогдох тооцоо судалгаа гаргах
- Тухайн бүсийн аялал жуулчлалыг орон нутгийн онцлогт тулгуурлан улсын жишиг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болох олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тогтвортой аялал жуулчлалыг тодорхойлж үнэт зүйл, давуу тал, онцлогийг илэрхийлсэн алсын харааг боловсруулах
- Хөвсгөл нуур орчимд эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж
- Улсын болон орон нутгийн Аялал жуулчлалын бүсийг тодорхойлох
- Монгол Улс болон бүс нутгийн хэмжээнд тухайн төслийн үзүүлэх нөлөөлөл, хөгжүүлэх зорилгыг тодорхойлох
- Дотоод гадаадын аялагчдыг хүлээж авах хүчин чадал, даацыг тодорхойлох.
- Аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх зорилтуудыг судалгааны шатанд тодорхойлж гаргах.

		<ul style="list-style-type: none"> - Орон зайн төлөвлөлтийн санал - Зам тээврийн сүлжээ - Ажиллах хүчний тооцоо - Инженерийн дэд бүтцийн хүчин чадлын тооцоо - Бүтээн байгуулалт, санхүүжилт, хөрөнгө оруулалт - Бүтээн байгуулалтын үе шат, удирдлага - Хөрөнгө оруулалт, санхүүжилт - Төслийн орлогын урьчилсан төсөөлөл - Эрсдэлийн үнэлгээ, удирдлага <p>Газар зохион байгуулалт</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөлтөөр хийгдсэн авто зам, зогсоол талбайг бусад холбогдох төлөвлөлтөд тусгаж ажиллах. <p>Хог хаягдал</p> <ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын цэгүүд болон төвлөрүүлэх газруудын байршлыг тодруулж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох; - Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, зайлуулах, дахин ашиглах, устгах, тусгай цэг байгуулах менежментийн төлөвлөлтийг боловсруулж тусгах; <p>Гамшгийн менежмент</p> <ul style="list-style-type: none"> - Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, шаардлагатай тохиолдолд үйлчлэх онцгой байдлын газар, гал унтраах ангийн хамрах хүрээ, аюулын дуут дохио, хорогдох байр, түр цуглах талбайн судалгаа гаргаж, хүчин чадал, хүрэлцээг одоогийн байдлаар тодорхойлох; - Гамшгийн аюулд өртөх магадлалтай газар нутаг, айл өрх, эдэлбэр газрын судалгааг гаргаж төлөвлөлтөд тусгах; <p>Мэдээлэл холбоо</p> <ul style="list-style-type: none"> - Харилцаа холбооны станцын байршил, дамжуулах сүлжээ, технологийн шийдэл, барилга байгууламжийн хэмжээ, хүчин чадлыг гаргах; - Худаг сувагчлал, кабелийн байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал, хамрах хүрээг төлөвлөх; - Үүрэн холбооны станцыг өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан дамжуулах сүлжээтэй хамт төлөвлөх; - Гамшгийн үед зарлан мэдээлэх системийн төлөвлөлт хийх - Шилэн кабелийн сүлжээний мэдээллийг гаргах; <p>Дүгнэлт, зөвлөмж</p>
8.	<p>Үйлчилгээ үзүүлэх этгээдэд тавигдах шаардлага</p>	<p>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь бүсчилсэн хөшжил, аялал жуулчлалын чиглэлээр судалгаа, зөвлөх үйлчилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байна. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь дараах шалгуурыг хангасан байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аялал жуулчлалын болон бүс орон нутгийн хөгжлийн чиглэлээр судалгаа, зөвлөх үйлчилгээ, бодлогын судалгааны үйл ажиллагаа явуулж байгаа;

2. Тухайн байгууллага болон тухайн байгууллагын санал болгож буй зөвлөхүүд нь аялал жуулчлал, бүс орон нутгийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийж байсан, тухайн чиглэлээр төрийн бодлого боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай (сүүлийн 5 жилийн хугацаанд дээрх чиглэлээр 2 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн);
3. Бодлогын судалгаа, стратеги, төлөвлөгөө боловсруулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай (сүүлийн 5 жилийн хугацаанд чиглэлээр 3 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн);
4. Олон нийтийн санаа бодлын судалгаа, хэлэлцүүлэг, үндэсний хэмжээнд өргөн хүрээг хамарсан судалгааны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх хүний нөөцийн болон техникийн хүчин чадалтай, ийм хэмжээний ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай (сүүлийн 2 жилийн хугацаанд 5 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн);
5. Олон нийттэй харилцах, маркетинг сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг туршлагатай;

Хуулийн этгээд нь дараах голлох мэргэжилтнүүдээс бүрдэх багийг ажиллуулах ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бусад хүний нөөцийг бүрдүүлсэн байна.

Багийн ахлагч нь:

- Бизнесийн удирдлага, аялал жуулчлалын менежмент, бүс нутгийн удирдлага, нийгмийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Судалгаа төлөвлөлтийн чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
- Сүүлийн 5 жилийн хугацаанд 3 болон түүнээс дээш тооны төрийн бодлого, стратеги боловсруулах ажилд оролцож ажилласан туршлагатай байх.

Судалгаа, стратеги төлөвлөлтийн мэргэжилтэн- Судлаач;

- Статистик, социологи, бизнесийн удирдлагын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
- Төрийн бодлого, стратеги, хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 3 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн туршлагатай байх.

Аялал жуулчлалын судлаач-Зөвлөх:

- Аялал жуулчлал, бүс нутгийн хөгжил, стратегийн төлөвлөлтийн чиглэлээр докторын зэрэгтэй;

		Аялал жуулчлалын чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан, аялал жуулчлалын чиглэлээр 3 болон түүнээс дээш тооны судалгааны ажлыг хэвлүүлсэн туршлагатай байх
9.	Ажлын үе шатанд тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none"> - Хөвсгөл нуурын тухайн бүсэд экологийн тэнцвэрт байдал, нөөц баялгийг хадгалан авч үлдэх, байгаль орчны онцгой хамгаалалтын бүсүүдийг тогтоох, түүх соёл архитектурын дурсгалыг хамгаалах, эрүүл ахуй, галын аюулгүйн шаардлагыг хангах хамгаалах арга замыг тусгах, - Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч буй иргэдээс төлөвлөлтөд тусгах зорилгоор санал асуулга, судалгаа явуулсан байх; - Аялал жуулчлалын маршрут, дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх, төлөвлөлт хийхдээ мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх, урьдчилсан байдлаар санал авсан байх шаардлагатай; - Авто зогсоол, явган зам, унадаг дугуйн зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам талбай төлөвлөх, тохижилтын ажлын зураг хийх; - Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талбайг бэлтгэх, хэрэгжүүлэх арга замыг судлан тусгах; - Төлөвлөлтийн шийдлийг эх загвар зураг, эскизийн шатанд зөвшилцөх; - Шинээр боловсруулах ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг өмнө нь хийгдсэн ерөнхий төлөвлөгөөнүүдтэй уялдуулан нэгдсэн шийдэл гаргах; - Зураг төслийг экспертизээр оруулж хянуулах. - Макет III зэрэг (Ерөнхий төлөвлөгөө, ХЕТ) - Авто болон явган аялагчийн нэвтрэх хаалтыг хийхдээ олон улсын жишигт нийцсэн шийдлүүдээс боломжит хувилбарыг сонгох, нэвтрэх хураамжийн төлбөрийг ухаалаг системээр шийдэх арга зам, аргачлалыг гаргах. - Нэн ховор, ховор амьтан, ургамлын жагсаалт, байршлыг 6, 7, 8 дугаар саруудад үзэж болох ургамлын жагсаалтыг нарийвчлан гаргах - Дээд, доод ургамлын ангилал зүй, зүйлийн бүрэлдэхүүнийг ам тус бүрээр гаргах, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах. - Аяллын маршрутыг ховор Амьтан, Ургамалын нягтшил бага газраар төлөвлөх. - Судалгааны дагуу гарсан материалыг ашиглан мэдээ, мэдээллийн самбарууд төлөвлөх.
10.	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл:	<p>Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр гүйцэтгэх хугацааг үндэслэл болгоно.</p> <p>Эхлэлийн тайлан:</p> <ul style="list-style-type: none"> - Одоогийн байдлын төлөв байдлын судалгаа, байр зүйн зураглал, инженер геологи, түүхэн барилга байгууламжийн судалгаа дууссан байх, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн тооцоолол боловсруулах; - Дундын тайлан: Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байх; - Төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэг хийх /Мэргэжлийн байгууллагууд болон төр захиргааны байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх/


		Эцсийн тайлан: Сайдын зөвлөлийн хуралд танилцуулах хурлаас гарсан санал, дүгнэлтийг тусгаж, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх;
11.	Захиалагч байгууллага	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БОЛОРМАА

БОЛОВСРУУЛСАН:
АЖБХЗГ-Н МЭРГЭЖИЛТЭН



Д.ГАНБААТАР